



TSX:ERD | MSE:ERDN | OTC:ERDCF

ӨНДӨР АГУУЛГА БҮХИЙ ХӨНДИЙ ЭРДСИЙН ДҮҮРГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ

Эрдэнэсийг нээж – өгөөжийг түгээе

2024 оны 3-р улирал

УРЬДЧИЛСАН ТААМАГЛАЛ

Уг танилцуулга нь урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг мэдэгдэхээс гадна урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн Компанийн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, эдийн засгийн нөхцөл байдалд тулгуурлан гарсан одоогийн үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Урьдчилсан таамаглал нь дараах үгсээр тодорхойлогдоно. Үүнд: (урьдчилан сэрэмжлүүлэх), (төлөвлөх), (зорилго), (эрэх хайх), (итгэх), (төсөвлөх), (үнэлэх), (тооцоолох), (стратеги), (ирээдүй), (боломжит байдал), (таамаглах), (байх) зэрэг ирээдүй цагт хамааралтай үгсээр илэрхийлэгдэнэ. Зарим нэг тодорхойгүй болон урьдчилсан харах боломжгүй нөхцөл байдал нь компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх магадлалтай. Эдгээр хүчин зүйлд материаллаг байдлаас хамааран зах зээлийн үнэ, хайгуул болон олборлолтын үр дүн, санхүүжилтийн нөхцөл байдал болон ерөнхий эдийн засаг, зах зээл, бизнесийн нөхцөл байдлууд орно. Компанийн урьдчилсан таамаглал нь энэхүү мэдэгдлээр илэрхийлэгдэж буй хөрөнгө оруулагчдад анхааруулах мэдэгдэл юм. Дээрх урьдчилсан таамаглал дахь мэдээллээс гадна энэхүү танилцуулгад: хайгуулын судалгааны үр дүн, нөөцийн тайлангийн үр дүн, шинэ эрдсийн нөөцийг тодорхойлох, баялгийг нөөцөд шилжүүлэх, нэмэлт хөрөнгө оруулалт татах, ирээдүйн санхүүжилт, хөрөнгийн зардал болон зардлууд, үүнд төсөвлөсөн зардлууд, Компанийн байгаль орчин, аюулгүй ажиллагаа болон бусад төслийн хөгжүүлэлттэй холбоотой тусгай зөвшөөрлийн нөхцөлүүд, үнэт металлын үнийн төсөөлөл, тусгай зөвшөөрлийн хүсэлт, авах тухай мэдээллийг агуулсан.

Урьдчилсан таамаглал нь төсөөлөл болон тооцоололд тулгуурласан бөгөөд дээрх мэдээлэл, мэдэгдлүүд нь үндэслэлтэй гэж үзэж байгаа боловч бизнес, эдийн засаг болон өрсөлдөх чадвартай холбоотой тодорхойгүй, тооцоологдоогүй байдлыг үүсгэх боломжтой. Энэхүү хүчин зүйлд алт болон бусад эрдсийн бүтээгдэхүүний үнэ, Компани ирээдүйд хөрөнгө босгон бизнесийг үргэлжлүүлэх чадвар, засгийн газар болон захиргааны байгууллагын хууль тогтоомжийн өөрчлөлт, татварын орчин, Монгол улс дахь эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал, Компанийн нөөцийн тодорхойлох чадвар, эрдсийн агуулга, анхан шатны эдийн засгийн тооцоолол, Хөндий төслийн геологи, судлын структур, ашиглалт болон хөгжүүлэлттэй холбоотой эрсдэлүүд, мөн хайгуул, олборлолттой холбоотой эрсдэлүүд үүнд шаардлагатай тусгай зөвшөөрлийг авах боломж, хангамж болон техник тоног төхөөрөмжийг хангах чадвар зэрэг багтана.

Уншигчдад анхааруулахад энэхүү урьдчилсан таамаглал дахь мэдээлэл нь Компанийн ирээдүйн үйл ажиллагааны баталгаа болохгүй. Эдгээр мэдэгдэл, мэдээлэл нь ирээдүйн үйл ажиллагаанаас шалтгаалан, тодорхойгүй байдал болон эрсдэлүүдээс шалтгаалан өөрчлөгдөх магадлалтай. Дээр дурдсан эрсдэлүүдэд алтны үнийн хэлбэлзэл, хайгуулын боломж, нөөцийн тодорхойгүй байдал, эрдсийн агуулга болон металл авалтын тооцоолол, хайгуул болон хөгжүүлэлтийн төлөвлөгөө саатах, санхүүжилт саатах, шаардлагатай тусгай зөвшөөрөл саатах, ордуудын эдийн засгийн тооцоолол буурах, хайгуул болон хөгжүүлэлтийн зардал, уул уурхайн салбарын өрсөлдөх чадвар, голлох удирдах албан тушаалтан, ажилтантай холбоотой эрсдэл, COVID-19-өөс үүсэх нөлөөлөл, маргаан, засгийн газар, хууль эрхзүйн байдалтай холбоотой өөрчлөлтүүдээс үүсэх зардлын өсөлт, байгаль орчны зардал, эрсдэл, гэмтэл болон хөдөлмөртэй холбоотой маргаан гарах зэрэг багтах боловч үүгээр хязгаарлагдахгүй. Дээрх эрсдэлүүд гарч, компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх тохиолдолд энэхүү урьдчилсан таамаглал, мэдэгдэлд тусгагдсанаас өөрөөр нөлөөлөх, материаллаг өөрчлөлт гарах боломжтой. Компанийн жилийн тайлан дахь эрсдэлийн хүчин зүйлтэй www.erdene.com-оос, эсвэл www.sedar.com-д тайлагнаснаар танилцаж болно. Компани хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд ирээдүйд энэхүү урьдчилсан таамаглалтай холбоотой мэдээ мэдээллийг шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн Ахлах геологич (Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба энэ танилцуулгад багтсан техникийн мэдээллийг Эрдэнэ Ресурсийн өмнөөс хянан баталгаажуулсан болно. Бүх валютын нэгж нь өөрөөр заагаагүй тохиолдолд Канад доллараар тайлагнагдсан. Энэхүү танилцуулга нь англи хэл дээр бэлтгэгдсэн танилцуулгын орчуулга болно. Англи, Монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.



ӨНДӨР АГУУЛГА БҮХИЙ ХӨНДИЙ ЭРДСИЙН ДҮҮРГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ

Хөрөнгө оруулалтын онцлогууд

Транс Алтайн Террейн дэх хязгаарлагдмал хайгуул хийгдсэн томоохон **зэс болон алтны бүсэд** төвлөрдөг


Баянхөндий алтны төсөл – **өндөр агуулга бүхий алтны төслийг** олборлолтын шат руу хөгжүүлж байна

Олон сая унц бүхий нөөцийн боломж – Дүүргийн хэмжээнд нөөцийг нэмэгдүүлэх хайгуулын боломжууд өндөр

Стратегийн түнш – Монголын уул уурхайн томоохон олборлогчтой стратегийн түншлэлийн гэрээ байгуулсан

Ази тивд хөгжүүлэлт хийгдээгүй хамгийн том **молибден-зэсийн орд**-ын нэг болох Зуун Мод ордын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг


ХӨНДИЙ ЭРДСИЙН ДҮҮРЭГ



ИРЭЭДҮЙ: АЛТ, ЗЭС, МОЛИБДЕН, МӨНГӨ, ХАР ТУГАЛГА БОЛОН ЦАЙРЫН ОЛБОРЛОЛТ

АРЛАН НУМЫН ДАГУУ ОРШДОГ ТОМООХОН АЛТ ЗЭСИЙН ОРДУУД

Хөндий Эрдсийн Дүүрэг: Хязгаарлагдмал хайгуул хийгдсэн өндөр хэтийн төлөв бүхий бүс




Арлан нумтай холбоотой металлоген бүсүүдийн дагуу томоохон ордуудын байршил (ягаан өнгө)
World of Maps™-аас газрын зургийг буулгав (© Bruce Jones Design, 2010).

ДЭЛХИЙН ХЭМЖЭЭНИЙ АЛТ – ЗЭСИЙН БҮСЭД ТӨВЛӨРСӨН

Монгол Улсын баруун өмнөд бүсэд хязгаарлагдмал хайгуул хийгдсэн - Транс Алтайн Террейн

МУРУНТАУ, ОЮУ ТОЛГОЙ ЗЭРЭГ ТОМООХОН АЛТ-ЗЭСИЙН ОРДУУДЫГ АГУУЛДАГ




USGS Судалгаагаар Төв Азийн Орогенийн Бүс дэх Транс Алтай нь Порфир, Эпитермаль зэс-алтны нээлтүүдийг хийх өндөр боломжтой хэмээн тодорхойлсон

Тэмдэглэл¹:

Агуулсан алт = Боломжтой нөөцийг багтаан ~53 сая.унц
Агуулсан зэс = Боломжтой нөөцийг багтаан ~39 сая.т



Эх сурвалж : Rio Tinto 2022 Annual Report



АЛТ ЗЭСИЙН ОРДУУДЫГ НЭЭХ БОЛОМЖТОЙ БҮС НУТАГ


Төв Азийн Орогенийн Бүс ба Зүүн Тетисид - USGS

“Хайгуул хийхэд хүндрэлтэй алслагдмал байдал, дэд бүтэц багатай нь баруун урд бүсэд хайгуул хязгаарлагдмал хийгдэх нөхцөл үүсгэсэн.”*



МОНГОЛ УЛСЫН БАРУУН ӨМНӨД ЗҮГИЙН ДЭД БҮТЭЦ САЙЖИРСААР БАЙНА

БНХАУ-ын хилээс 200км зайд байрладаг



ОЛОН ОРДУУДИЙГ НЭЭХ БОЛОМЖ БҮХИЙ ХӨНДИЙ ЭРСДИЙН ДҮҮРЭГ

Ордуудыг үргэлжлүүлэн олборлох боломжтой, +20 хэтийн төлөв бүхий талбай



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БОЛОН ОЛБОРЛОЛТЫН ТУРШЛАГА НЭМЭГДҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ТҮНШЛЭЛ

Монголын тэргүүлэх хайгуул болон олборлолтын компаниуд хамтран ажиллана



TSX : ERD
Эрик Спротт (18%)
ЕСБХБ (8%)

MSE : ERDN
7,000 гаруй Монгол
хувьцаа эзэмшигчидтэй

Эрдэнэ Монгол ХХК

Алт

MMC-тэй 50:50 хамтран эзэмших

Транс Алтайн Террейн

Дэлхийн хэмжээний алт - зэсийн бүс

Дүүргийн хэмжээний боломж
700 км² талбайд 5% NSR*

Аниан Ресорсиз ХХК

Молибден - зэс

100% эзэмшил
Томоохон зэс-молибденийн төсөл

Баянхөндий
Алтны төсөл

Хар Морь
Алтны төсөл

Хөндий
Ашиглалтын тусгай
зөвшөөрөл

Алтан Нар
Алт-полиметаллын төсөл

Алтан Нар
Ашиглалтын
тусгай зөвшөөрөл

Улаан
Алтны төсөл

Улаан
Хайгуулын тусгай
зөвшөөрөл

Зуун Мод
Зэс-молибденийн
төсөл

Хөвийн Хар
Зэсийн төсөл

Хөвийн Хар
Ашиглалтын тусгай
зөвшөөрөл



МОНГОЛИАН МАЙНИНГ КОРПОРЭЙШНТЭЙ ХИЙСЭН СТРАТЕГИЙН ТҮНШЛЭЛ

Монгол Улсын хамгийн том хувийн хэвшлийн олборлогч компани

- **Монголиан Майнинг Корпорэйшн (“ММС”) нь Монгол Улсын хамгийн том үнэт цаасыг нээлттэй арилждаг олборлогч компани**
 - Хонг Конгийн хөрөнгийн биржид (HKEx: 975) бүртгэлтэй
 - Зах зээлийн үнэлгээ ~\$1 тэрбум ам.доллар (2024, 2-р улирал)
 - ММС-ийн 40%-ийг Монголын томоохон групп компаниудын нэг М-Си-Эс Групп эзэмшдэг
- **ММС нь уул уурхайн бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэхээр зорин ажиллаж байна**
 - ММС нь Өмнөговь аймагт байрлах Ухаа Худаг (“УХ”), Баруун Наран (“БН”) коксжих нүүрсний уурхайд үйл ажиллагаа явуулдаг
- **Үйл ажиллагааны туршлага**
 - 15 жилийн турш үйл ажиллагаа эрхэлж буй туршлагатай (+2,000 ажилтантай)
 - Аюулгүй байдлын өндөр соёл – 2022 онд 6.9 сая хүн цагт хугацаа алдсан гэмтэл 3 бүртгэгдсэн
 - Орон нутгийн эдийн засагт томоохон хувь нэмэр оруулагч бөгөөд 4.6 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж, орон нутгаас ажиллах хүчний 40%-ийг бүрдүүлдэг



М-СИ-ЭС ГРУПП – ММС-ИЙН ХАМГИЙН ТОМ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

Монгол Улсын тэргүүлэгч групп компани

- **Монгол Улсын тэргүүлэгч групп компаниудын нэг**
 - ММС-ийн 40%-ийг эзэмшдэг бөгөөд Монголд 30 гаруй жил үйл ажиллагаа явуулж буй туршлагатай
 - Инженерчлэл, эрчим хүч, харилцаа холбоо, үл хөдлөх хөрөнгө, уул уурхай, өргөн хэрэглээний бүтээгдэхүүн, эрүүл мэнд, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж ирсэн
- **13,000 гаруй ажилтантай**
 - Монгол Улсын эдийн засагт жил бүр дунджаар 500 сая ам.долларын хувь нэмэр оруулдаг.
 - Монгол Улсын хамгийн том татвар төлөгчдийн нэг
- **М-Си-Эс нь хариуцлагатай, шилдэг засаглал, дэвшилтэт технологийг нэвтрүүлэн, Монгол Улсын эдийн засагт дорвитой хувь нэмэр оруулахыг эрмэлзэн ажилладаг**
 - М-Си-Эс нь үйл ажиллагаа явуулж буй орон нутагтаа өгөөжийг нэмэгдүүлэхийг эрмэлздэг
 - Групп нь тогтвортой байдлын нарийвчилсан тайланг гаргадаг

Source: www.mcs.mn



ТӨСЛИЙН САНХҮҮГИЙН ХАМТРАГЧИД

Олон улсын болон дотоодын тэргүүлэгч санхүүгийн байгууллагуудын дэмжлэг



Монголиан Майнинг Корпорэйшн - Хувьцаа

- Эрдэнэ Ресурсийн охин компанид 40 сая ам.долларын хувьцааны санхүүжилт
- Жилд ~500 сая ам.долларын EBITDA₁

Монголиан Майнинг Корпорэйшн - Зээл

- Хувь эзэмшигчийн зээл хэлбэрээр 50 сая ам.долларыг 5 жилийн хугацаанд санхүүжүүлнэ
- 13.8%-ийн хүүтэй ба зээлийн хугацаа дуусахад бүрэн төлсөн байх нөхцөлтэй
- Адил нөхцлөөр дахин 30 сая ам.долларын зээлийг авах боломжтой
- Эрдэнэ Ресурс нь MMC-тэй адил нөхцлөөр 50%-ийн зээлийг олгох боломжтой



Монголбанк & Монголын арилжааны банкууд

- Засгийн газрын хөтөлбөрүүд нь алт, олборлолтын салбарын оролцогчдод зээл олгох, татварын тогтворжуулах гэрчилгээг олгох зэргээр дэмжлэг үзүүлдэг
- 30 сая ам.доллар хүртэл эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийг арилжааны банкуудаас татан төвлөрүүлэх боломжийг судалж байна



Европын Сэргээн Босгох, Хөгжлийн Банк

- 2020 оны 4-р улиралд зээлийн хөрвүүлэлт хийснээр гол хувьцаа эзэмшигчдийн нэг болсон (8%)
- Монгол Улсад 2.3 тэрбум еврогийн хөрөнгө оруулалт хийсэн ба хамгийн том гадаадын шууд хөрөнгө оруулагч

Eric Sprott

Эрик Спротт

- Эрдэнэ Ресурсийн хамгийн том хувьцаа эзэмшигч (18%)




Монголын Хөрөнгийн Бирж

- Монголын Хөрөнгийн Бирж дээр 7,000 гаруй хувьцаа эзэмшигчидтэй: Монголын хөрөнгийн бирж, Торонтогийн хөрөнгийн биржид (TSX:ERD | MSE:ERDN) давхар бүртгэлтэй анхны компани

БАЯНХӨНДИЙ ОРДЫН ЗУРАГ



БАЯНХӨНДИЙ ТӨСЛИЙН ЗУРАГЛАЛ / 2024, 3-р улирал/



Уурхайн загварчлал

Түр кэмп

Хаягдлын талбай

Шимт хөрсний овоолго

Буцаан дүүргэх материал

Засварын цех

Буцаан дүүргэх материал

Материал байршуулах талбай

Захиргааны барилга

Шатахуун түгээх түр станц

Үйлдвэрийн барилга, агуулах, лаборатори, химийн агуулах

Материал байршуулах талбай

Дулааны станц

Бутлуурын хэсэг

Бетон зуурмагын үйлдвэр

Түр барилга



БАЯНХӨНДИЙ ОРД – СУДЛЫН ДАГУУ БОЛОН ГҮН РҮҮ ТЭЛЭХ БОЛОМЖТОЙ

Өнөөгийн *Виттл* ордын хязгаар нь хүдэржсэн бүсийн багахан хэсгийг эзэлж байна




Хойд Хар Морь болон Алтан сум талбайг хамарсан Хар Морь талбай; хайгуул хийгдэж буй

Баянхөндий орд
CIP үйлдвэр

Алтны нөөц
513,700 унц @ 4 г/т

Өмнөд Хар Морин Дэл
Газрын дөт гүнд өндөр агуулга бүхий исэлдсэн алт



0-7 жилийн хөгжүүлэлт
>3.8 сая тонн, >3.8 г/т алтны агуулга
ордын гүн: <150 метр гүн

3 дахь жилээс хөгжүүлэлт
>200,000 тонн @ >7 г/т алтны агуулга
газрын дөт гүнд илээр олборлох боломжтой

Баруун Баянхөндий нөөц:
Баруун Страйкер, Улаан



- Алт $\geq 0.1\text{г/т}^*$
- Аномаль индикатор*
($\pm\text{Sb, As, Qtz}$ судал, хувирал)

*Инторполяци хийгдсэн үр дүнд тулгуурлав



БАЯНХӨНДИЙ АЛТНЫ ОРД

Олон орд бүхий эрдсийн дүүргийн суурь төсөл

2025

Дэлхийн хэмжээний хамгийн өндөр агуулга бүхий хөгжүүлэлт хийж буй ордуудын нэг – 2025 оны 2-р улиралд олборлолт эхлэнэ

26

Монгол Улсад 26 жил үйл ажиллагаа явуулж буй;
Төсөл хэрэгжүүлж буй орон нутагтай хамтран ажиллаж, хувь нэмэр оруулдаг

93%

Газрын дөт гүнд, 150м хүртэл;
Нүүрсэнд уусгах технологи ашиглах бөгөөд 93% металл авалт бүхий 6 жил илээр олборлох уурхай

Өсөх боломж

Уурхайн ашиглалтын хугацааг нэмэгдүүлэх боломжтой:
3 орд болон +20 хэтийн төлөв бүхий талбай

ХӨНДИЙ ЭРДСИЙН ДҮҮРГИЙГ ТЭЛЭХ ӨНДӨР ӨГӨӨЖ, БАГА ЗАРДАЛ БҮХИЙ СУУРЬ ТӨСӨЛ

Баянхөндийн шинэчилсэн ТЭЗҮ-ээр эерэг үр дүнг танилцуулсан



4.0 г/т

Дундаж агуулга

869 ам.дол/унц

Унц алтны нийт нэгжийн өртөг (AISC)

42%

Дотоод өгөөжийн түвшин (IRR)

2.05 жил

Эргэн төлөгдөх хугацаа

100 сая ам.дол

Анхан шатны хөрөнгө оруулалт

86,900 унц

Жилийн дундаж олборлолт (2-5 жилд)

223 сая ам.дол

Өнөөгийн үнэ цэн (NPV_{5%} | 2000 ам.дол/унц)

513,700 унц

Алтны нөөц


2023 ТЭЗҮ-ийн үр дүн




АЛТНЫ ҮНИЙН ХАМААРАЛ

Алтны үнийн өсөлт нь төслийн эдийн засагт эерэгээр нөлөөлнө

Татварын дараах өнөөгийн үнэ цэн (NPV5%)
алтны үнийн хамаарал




Дотоод өгөөжийн түвшин (IRR)
алтны үнийн хамаарал



2025 ОНООС ӨСӨЛТИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ МӨНГӨН УРСГАЛ

Суурь тооцооллоор (US\$1800) жилийн дундаж мөнгөн урсгал 60 сая ам.дол ба алтны үнэ US\$2200 үед ~\$100 сая ам.дол болж өснө


Татварын дараах мөнгөн урсгалын тооцоолол



БАЯНХӨНДИЙ ТӨСЛИЙН ШИНЭЧИЛСЭН ТЭЗҮ

2020 оны ТЭЗҮ-тэй харьцуулахад алт авалтыг 25%-иар нэмэгдүүлэв

| Баянхөндий | | Хар Морь | | Нийт | |
|--------------|---------------|--------------|---------------|--------------|----------------------|
| Хүдэр | - 3.8 сая тн | Хүдэр | - 0.2 сая тн | Хүдэр | - 4.0 сая тн |
| Агуулга | - 3.8 г/т алт | Агуулга | - 7.0 г/т алт | Агуулга | - 4.0 г/т алт |
| Металл авалт | - 93% | Металл авалт | - 89% | Металл авалт | - 93% |
| Олборлох алт | - 432,000 унц | Олборлох алт | - 44,000 унц | Олборлох алт | - 476,000 унц |



БАЯНХӨНДИЙ АЛТНЫ ТӨСӨЛ: БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР /2024, 3-р улирал/



БАЯНХӨНДИЙ АЛТНЫ ТӨСӨЛ : БУТЛУУРЫН ХЭСЭГ /2024, 3-р улирал/



БАЯНХӨНДИЙ ТӨСЛИЙН ТАЛБАЙ / 2024, 3-р улирал /



БАРИЛГА, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БОЛОН ЭРЧИМ ХҮЧНИЙ ГЭРЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН

Голлох бүтээн байгуулалтын гэрээнүүдийг эцэслэн, тээвэрлэлтийн үйл ажиллагаа тогтвортой явагдаж байна

MCSP

М-Си-Эс Проперти ХХК-тай инженер, худалдан авалт барилга угсралтын гэрээг байгуулсан

- 25 жилийн туршлага бүхий +1,500 ажилтан, +225 инженерийн хүний нөөц бүхий томоохон барилгын компани
- Рио Тинтогийн Оюу толгой, MMC-ийн Ухаа худаг уурхайн барилга угсралтад оролцсон уул уурхайн салбарын томоохон гүйцэтгэгч
- MMC-ийн голлох хөрөнгө оруулагч М-Си-Эс Групп эзэмшдэг
- Аюулгүй байдлын өндөр соёл – 2022 онд 6.9 сая хүн цагт хугацаа алдсан гэмтэл 3 бүртгэгдсэн
- Гэрээний үнэлгээ бүтээн байгуулалтын бэлтгэл ажлуудыг оролцуулан 55 сая ам.дол

MCSI

М-Си-Эс Интернэйшнл ХХК-тэй эрчим хүч худалдан авах гэрээг байгуулсан

- 14.5МВт-ын дизель станц, 5МБТ-ын сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, 3МВт/ц цэнэг хураагуурын агуулах бүхий хосолсон шийдэл ба дэд бүтцээс бүрдэнэ
- М-Си-Эс Интернэйшнл нь take-or-pay (хэрэглээнээс үл хамааран гэрээний дүнгээр төлбөр төлөх) зарчимд үндэслэн барьж, эзэмшиж, үйл ажиллагааг явуулна

Тоног
төхөөрөмжүүд

Боловсруулах үйлдвэрийн голлох тоног төхөөрөмжүүдийн худалдан авалтыг хийсэн

- Бөмбөлөгт болон хагас өөрөө нунтаглах тээрмийн худалдан авалтыг CITIC, элюцийн хэлхээний тоног төхөөрөмжийг COMO, шүүлтүүрийн тоног төхөөрөмжийг Hot Chengdu-ээс захиалсан
- Голлох тоног төхөөрөмжүүд (тээрэм, элюцийн хэлхээ, алтны өрөө, шигшигч болон тэжээгч зэргийн зарим нь төслийн талбайд хүргэгдэн, үлдсэн нь тээвэрлэлт хийгдэж буй)




Оюу Толгой далд уурхайн конвейер – MCSP



18МВт Ухаа худаг цахилгаан станц – MCSI

2025 ОНД АЛТНЫ ОЛБОРЛОЛТЫГ ЭХЭЛНЭ

2023 онд бүтээн байгуулалтын бэлтгэж ажлуудыг эцэслэсэн



[Solid orange bar] Гүйцэтгэсэн

[Dashed blue bar] Үргэлжилж буй

[Checkmark icon] Дуусах огноо



АЛТ, ЗЭС, МОЛИБДЕНИЙН ОРДУУД БОЛОН ХЭТИЙН ТӨЛӨВ БҮХИЙ БҮСҮҮД

Дөрвөн алтны шинэ нээлт, молибден-зэсийн орд болон +20 гаруй хэтийн төлөв бүхий бүсүүд




БАЯНХӨНДИЙ ОРД – МАШ ӨНДӨР АГУУЛГА БҮХИЙ НЭЭЛТҮҮД

150м-ээс доош хязгаарлагдмал хайгуул хийгдсэн 10 гаруй км-ийг хамарсан хүдэржсэн структур

| ХАР МОРЬ ОРД | | | | | |
|-------------------------|-------|----------|------|--------|-----|
| Онцлох алтны огтлолтууд | | | | | |
| Цооног | м-ээс | м хүртэл | м | Аu г/т | G*M |
| AAD-58 | 10 | 55 | 45 | 6.0 | 268 |
| AAD-137 | 1.5 | 26 | 24.5 | 9.4 | 230 |
| AAD-146 | 15 | 32 | 17 | 16.6 | 283 |
| AAD-177 | 1 | 24 | 23 | 11.4 | 262 |
| AAD-178 | 11 | 26 | 15 | 42.8 | 643 |

| БАЯНХӨНДИЙ ОРД | | | | | |
|-------------------------|-------|----------|-------|--------|------|
| Онцлох алтны огтлолтууд | | | | | |
| Цооног | м-ээс | м хүртэл | м | Аu г/т | G*M |
| BKD-292 | 0.9 | 23 | 22.1 | 20.0 | 442 |
| BKD-98 | 39 | 170.5 | 131.5 | 3.9 | 508 |
| BKD-261 | 13 | 125 | 112 | 5.9 | 661 |
| BKD-288 | 11.5 | 17 | 5.5 | 125.9 | 692 |
| BKD-231 | 193 | 207 | 14 | 158.3 | 2216 |

| УЛААН ОРД | | | | | |
|-------------------------|-------|----------|----|--------|-----|
| Онцлох алтны огтлолтууд | | | | | |
| Цооног | м-ээс | м хүртэл | м | Аu г/т | G*M |
| UDH-10 (D) | 99 | 139 | 40 | 3.8 | 151 |
| UDH-14 | 192 | 226 | 34 | 5.4 | 185 |
| UDH 22 | 85 | 150 | 65 | 3.1 | 202 |
| UDH-21 | 115 | 192 | 77 | 3.2 | 246 |
| UDH-35 | 187 | 228 | 41 | 8.1 | 332 |



- Алт ≥ 0.1 г/т*
- Аномаль Индикатор* (±Sb, As, Qtz судал, хувирал)
- Үндсэн структур
- Хоёрдогч структур

*Өрмийн үр дүнгийн интерполяцид тулгуурласан




БАЯНХӨНДИЙ ОРД – ӨНДӨР АГУУЛГА БҮХИЙ ШИНЭ НЭЭЛТҮҮД ХИЙХ БОЛОМЖ

Өнөөгийн ордын хязгаараас гадна хэд хэдэн өндөр агуулга бүхий интервал огтолсон



ХАР МОРЬ – МАШ ӨНДӨР АГУУЛГА БҮХИЙ ОРД

Өндөр хэтийн төлөв бүхий, газрын дөт гүнд 7 г/т дундаж агуулга бүхий исэлдсэн нөөц



ХАР МОРЬ ТАЛБАЙ


Өрөмдлөгийн онцлох үр дүнгүүд

Хар Морин Дэл структураас зүүн, баруун зүгт туршигдаагүй хэд хэдэн хэтийн төлөв бүхий талбай тодорхойлогдсон

ХАР МОРИН ДЭЛ АЛТНЫ ОРД

Хар Морин Дэл структур

ШИНЭ Зүүн Дэл Коридор





- Шинэ цооног
- Урьд танилцуулсан
- Цахилгаан туйлшралын градиент өндөр
- Боломжтой структурын цогцолбор
 - - - - Алттай холбоотой тэлэлтийн структур
 - - - - Гүн суулт бүхий структур / шингэн дамжуулагч



1 км

ЗҮҮН ӨМНӨД УЛААН – БАЯНХӨНДИЙТЭЙ ЗЭРЭГЦЭЭ ӨНДӨР АГУУЛГА БҮХИЙ ТАЛБАЙ

Баянхөндийгөөс баруун зүгт 300м-т өндөр агуулга бүхий структур



АЛТАН НАР – 5.6КМ ХҮДЭРЖСЭН СИСТЕМ

Баянхөндий ордоос хойд зүгт 16 км-т орших өндөр агуулга бүхий орд

| 2019 Нөөц | Ангилал | Au унц (1.9 г/т) | Ag унц (~10 г/т) | Pb фунт (~0.6%) | Zn фунт (~0.6%) |
|----------------------------------|------------------|---------------------|---------------------|--------------------|--------------------|
| Алтан Нар | Бодитой | 318,000 | 2,350,000 | 63,800,000 | 69,520,000 |
| 0.7г/т AuEq захын агуулга | Боломжтой | 186,000 | 866,000 | 49,060,000 | 52,140,000 |

Карбонат суурь металл – дундаж сульфиджилт орд нь дараах дэлхийн томоохон ордуудтай төстэй:

- Fruta del Norte (Эквадор): 6.7 сая унц алт
- Porgera (Шинэ Гвиней): >25 сая унц алт
- Kelian (Индонез): 5.7 сая унц алт
- Montana Tunnels (АНУ): 36 сая унц алт
- Roşia Montană (Румын): 17 сая унц алт

Бага өрөмдлөгөөр нөөцийг материаллаг хэмжээгээр нэмэгдүүлэх өндөр боломжтой

- Нөөцийг 5.6км x 1.5км хэмжээтэй хүдэржсэн коридор дахь хоёр бүсэд төвлөрч тооцоолсон
- Трендийн дагуу +20 гаруй хүдэржсэн хэтийн төлөв бүхий бүсүүд
- Газрын дөт гүнд – Нөөцийн 90% нь газрын гадаргаас 150 метрт бөгөөд гүндээ нээлттэй




АЛТАН НАР ОРД – НЭЭЛТИЙН БҮС

Орд нь гүндээ нээлттэй бөгөөд хэд хэдэн цооног хүдэржилтээр төгссөн

Өндөр агуулга бүхий Нээлтийн Бүс

TND-101:
104 г/т Au бүхий 4м, 108 г/т Ag,
3.7% Pb ба 5.9% Zn

TND-135:
45.7 г/т Au бүхий 7м, 93 г/т Ag,
1.5% Pb ба 3.4% Zn



Нээлтийн Бүсийн хүдэржилт нь галт уулын брекч болон андезитийн шүргэлцэл дээр үүссэн

100м зузаан хөндлөн зүсэлт - Зүүн хойд зүгт

| | м-ээс | м хүртэл | өргөн | Au г/т | Au Eq г/т |
|---------|-------|----------|-------|--------|-----------|
| TND-69 | 47 | 91 | 44 | 2.3 | 3.2 |
| TND-90 | 91 | 131 | 40 | 2 | 2.8 |
| TND-91 | 78 | 81 | 3 | 0.92 | 1.8 |
| TND-101 | 39 | 82 | 43 | 4.6 | 5.70 |
| үүнд | 76 | 78 | 2 | 56.3 | 59.8 |
| ба | 94 | 140 | 46 | 17.5 | 19.2 |
| үүнд | 96 | 111 | 15 | 52.3 | 56.9 |
| ба | 158 | 170 | 12 | 2.8 | 3.3 |
| TND-104 | 126 | 163 | 37 | 2.2 | 2.50 |
| TND-105 | 100 | 114 | 14 | 7.9 | 10.20 |
| TND-110 | 97 | 117 | 20 | 10.3 | 11.80 |
| TND-134 | 101 | 111 | 10 | 12.2 | 13.4 |
| TND-135 | 97 | 120 | 23 | 17 | 18.8 |
| үүнд | 105 | 112 | 7 | 45.7 | 49.70 |




Галт уулын брекч ба андезитын шүргэлцлийг ашиглан филлийн хувирлаар хүрээлэгдсэн (хар/улаан) хүдэржсэн эпитеpmаль ба гидротермаль брекч

АЛТАН НАР БҮСИЙН ХАЙГУУЛ

Хайгуулын суваг малталт ба өрөмдлөг

- Цооног
- Тодорхойлсон нөөцийн бүс
- Хайгуулын зорилтот бүс
- Гадаргын сорьцлолт - алт
- Гадаргын сорьцлолт - зэс



Филлийн хүчтэй хувирсан бүсэд гадаргын сорьцолтоос өндөр аномальжсан зэс Cu порфирийн бүсүүд 14% Cu хүртэл

Алтан Нарын нөөцийн бүсээс гадна 34 хэтийн төлөв бүхий бүсийг тодорхойлсон

Зорилт: Өнөөгийн нөөцийн бүсээс гадна нэмж 300 мян. унц алттай дүйцэх нөөцийг тодорхойлох; +1 сая унц Баттай болон Бодитой нөөц тодорхойлох



ЗУУН МОД – АЗИ ТИВД ХӨГЖҮҮЛЭЛТ ХИЙГДЭЭГҮЙ ХАМГИЙН ТОМ МОЛИБДЕН-ЗЭСИЙН ОРДУУДЫН НЭГ

2023 онд молибденийн ханш хамгийн өндөр түвшинд хүрсэн

ЭЗЭМШИЛ

- Эрдэнэ Ресурсийн 100% эзэмшил
- 30+ жилийн уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй

БАЙРШИЛ

- Гангийн үйлдвэрлэлийн хамгийн том зах зээл, металлын хамгийн том хэрэглэгч БНХАУ-ын хилээс 180 км-т байрладаг
- Баянхөндий алтны төслөөс зүүн зүгт 30 км-т оршдог

МОЛИБДЕНИЙН ЗАХ ЗЭЭЛ

- Молибденийн ханш нь сэргээгдэх эрчим хүч, зэвэрдэггүй гангийн эрэлт болон молибденийн нийлүүлэлт багассантай холбогдон өссөн.
- Өнгөрсөн 2 жилийн хугацаанд молибденийн үнэ US\$20-\$40/фунт байв

ЗУУН МОД ТӨСӨЛ НЬ ДЭЛХИЙН ХАМГИЙН ТОМ ГАНГИЙН ҮЙЛДВЭРИЙН ЗАХ ЗЭЭЛТЭЙ ХИЛЛЭН ОРШДОГ


2022 онд БНХАУ дангаараа 20 сая фунт молибденийн хомстолд орсон



Зуун Мод тусгай зөвшөөрлийн борлуулалтын цэвэр ашгаас 1.5%-ийн төлбөрийг ("БЦАТ") Сэндбокс Роялти Корп-д өгөх нөхцөлтэй.
NI 43-101 Technical Report, Zuun Mod Porphyry Molybdenum-Copper Project, Minarco-MineConsult, June 2011

ЗУУН МОД – 16 КМ РАДИУСТ ЗЭСИЙН ГЕОХИМИЙН УЛ МӨР ИЛЭРДЭГ

Одоогийн хүдэржсэн бүсийн дотор болон гадна орших хэд хэдэн хэтийн төлөв бүхий бүсүүд нь гүндээ нээлттэй



ZMD-131: 277.6м
(0.83% Mo & 0.15% Cu(2м))

ZMD-131: 338.8м
(0.10% Mo & 0.06% Cu(2м))





43-101 нөөцийн тооцоолол, захын агуулга 0.04% Mo

| NI 43-101 ангилал | Зуун Мод Энгийн Кригинг тооцоолол | | | | | | |
|-------------------|-----------------------------------|-------|---------------|-------|---------------|--------|---------------|
| | Тонн сая тн | Mo % | Mo фунт (мян) | Cu % | Cu фунт (мян) | Re PPM | Re фунт (мян) |
| Баттай (M) | 40 | 0.056 | 49,500 | 0.064 | 57,000 | 0.225 | 20 |
| Бодитой (I) | 178 | 0.057 | 224,000 | 0.070 | 273,700 | 0.242 | 95 |
| M&I | 218 | 0.057 | 273,500 | 0.069 | 330,700 | 0.239 | 115 |



ЗҮҮН ХОЙД ЗУУН МОД: ТЭЛЭХ БОЛОМЖТОЙ ЗЭСИЙН БҮС

Хойд Зуун Модын хөндлөн зүсэлт D – хойд зүгт харсан




ЗУУН МОД – ӨНДӨР АГУУЛГА БҮХИЙ ЗЭСИЙН ОГТЛОЛ

ZMD-121 – Брекчийн бүс дэх халькопирит 2 метрийн турш 4.1% Cu @ 316.8 сая





ЗУУН МОДЫГ ОЮУ ТОЛГОЙТОЙ ХАРЬЦУУЛАХ НЬ

Зуун Мод ордын гадна томоохон талбай судлагдаагүй хэвээр байна






ZMD-121
34м 1.3% зэс
9.2 г/т мөнгө



ЗУУН МОД ЗЭСИЙН ПОРФИРИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ

- Зэсийн порфир илрэх магадлал өндөр
- UST (нэг чиглэл бүхий царцалт) хэд хэдэн илрэл, порфирийн системийн оройн орчимд байрладаг цахиурт бүрхүүлийн цухуйлт болон миаролитийн хөндийн бүтцийг илрүүлсэн
- 5 км-ийн диаметр бүхий талбайд, хөрсний аномальд зэс илэрсэн
- Хөвийн Хар талбайн хойд хэсэгт хайгуулын өрөмдлөг хийгдсэн бөгөөд өндөр аномаль зэсийн огтлолууд огтолсон
- Порфирийн ордууд нь ихэвчлэн бүлэг орд хэлбэрээр оршдог тул Зуун Мод орд нь дан орд биш байх магадлалтай




ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ДЭМЖЛЭГ

Хөрөнгө оруулалтын сангууд, банк болон хөрөнгө оруулагчид хувьцааны дийлэнх хувийг эзэмшиж байна


ХӨРӨНГИЙН БҮТЭЦ

| | |
|--------------------------------------|-----------|
| Эргэлтэд буй нийт хувьцаа | 348 сая |
| Опцион | 23 сая |
| Варрант | 24 сая |
| ИОХЭ | 10 сая |
| Бүрэн хорогдуулсан хувьцаа | 405 сая |
| Зах зээлийн үнэлгээ (сая кан.дол) | 142 сая |
| 52 долоо хоногийн ханшийн хэлбэлзэл | 0.27-0.52 |
| Өдөр тутмын арилжааны дундаж (3 сар) | 122,962 |

Тэмдэглэл: 2024.07.03-ны байдлаар




ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ӨГӨӨЖИЙН ХАРЬЦУУЛАЛТ



ҮНЭ ЦЭНИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖУУД





Баянхөндий төслийн мөнгөн урсгал нь Хөндий Эрдсийн Дүүргийн үнэ цэнийг нэмэгдүүлнэ



ДАХИН ҮНЭЛГЭЭ ХИЙХ БОЛОМЖТОЙ

Баянхөндий төслийн олборлолтыг эхлүүлснээр Эрдэнэ Ресурсийн хувьцаа дахин үнэлгээ хийгдэх боломжтой

- Бүтээн байгуулалтын шийдвэрийн өмнөх хувьцааны ханш
- Бүтээн байгуулалтын шийдвэрийн дараах хувьцааны ханш




Эх сурвалж: CapIQ; 2024.01.18




ДАХИН ҮНЭЛГЭЭ ХИЙХ БОЛОМЖТОЙ

Баянхөндий төслийн олборлолтыг эхлүүлснээр Эрдэнэ Ресурсийн хувьцаа дахин үнэлгээ хийгдэх боломжтой



■ Бүтээн байгуулалтын шийдвэрийн өмнөх хувьцааны ханш
 ■ Бүтээн байгуулалтын шийдвэрийн дараах хувьцааны ханш



Эх сурвалж: CapIQ; July 2024



НИЙГМИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

25 жилийн турш Монгол Улсад төвлөрч ажилласан



- Бүтээн байгуулалтын албан ёсны шийдвэр гарахаас өмнө +10 жилийн өмнөөс орон нутгийн хөгжлийг дэмжсээр ирсэн
- Үүсгэн байгуулагдсанаас хойш Монгол Улсад 100 гаруй сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн
- Баянхөндий алтны төслөөс Монгол Улсын засгийн газарт 6 жилийн турш 100 сая ам.долларыг татвар болон нөөц ашигласны төлбөрт төвлөрүүлж, 400 гаруй ажлын байр бий болгохоор тооцолсон ¹

- Нийгэм болон бизнесийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн
 - Петер Акерли 2019 онд Монгол Улсын Алтан гадас одонгоор шагнагдсан (гадаад улсын иргэнд олгодог төрийн хамгийн дээд хүндэт шагнал)

- **Эрдэнэ Ресурс нь Торонтогийн хөрөнгийн бирж, Монголын хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй анхны компани**
- Удирдлагын багийн 70 хувь нь Монгол Улсад оршин суудаг бөгөөд Монголын 7000 гаруй хувьцаа эзэмшигчидтэй



ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Үйл ажиллагаа эрхэлж буй орон нутагтаа үнэ цэнийг бий болгох нь



Эрдэнэ Ресурс нь Баянхонгор аймаг, Шинэжинст суманд хөрөнгө оруулалт хийсээр ирсэн

- Орон нутагтай өгөөжийг хуваалцах Хамтын ажиллагааны гэрээг 2020 онд байгуулсан.
- ТЭЗҮ, бүтээн байгуулалтын бэлтгэл ажлуудыг (2020-2024) гүйцэтгэсэн ба Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд 2.2 сая ам.доллар (~7 тэрбум төг)-ын хөрөнгө оруулалтыг эрүүл мэнд, дэд бүтцийн хөтөлбөрүүдэд оруулах үүрэг хүлээсэн.

Эрдэнэ Ресурс нь орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэх, иргэдийг чадавхжуулахыг зорьдог

- Олборлолт эхлэхэд уурхайн ажлын байрны 30%-иас доошгүй хувийг орон нутгийн иргэд эзэлнэ.
- 2023 онд орон нутгийн 50 иргэнийг төслийн талбайд ажиллуулж, 80 иргэнийг операторын сургалтад хамруулсан.



Орон нутгийн онцлогт тохируулан ажиллахыг эрмэлздэг

- Бид Шинэжинст суманд ус цэвэршүүлэх байгууламжийг барьж, сумандаа цэвэр ус ашиглах боломжийг бий болгосон.
- Цэцэрлэг, сургуулийн ариун цэврийн байгууламжийг шинэчилсэн.
- Орон нутгийн эдийн засагт нэн шаардлагатай чиглэлээр 100 гаруй оюутанд тэтгэлэг олгосон.
- Бид жил бүр өвс, нэмэлт тэжээл хандивлан, малчдыг дэмждэг.
- Бид Бритиш Колумбын их сургууль (БКИС) /MITACS-тай хамтран уул уурхайн салбарын орон нутагт оруулах өгөөжийн судалгааг хийсэн бөгөөд БКИС нь Эрдэнэ Ресурсийг орон нутгийн хөгжилд манлайлагч хэмээн тодорхойлсон.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Байгаль орчныг хамгаалж ажиллах нь

- **Эрдэнэ Ресурс нь байгаль орчны стандартыг дээд зэргээр сахин ажилладаг**

Бид нүүрсэнд уусгах технологийг ашиглан, хуурай хаягдал гаргахаар төлөвлөсөн нь усыг 85% дахин боловсруулж, усны дахин хэрэглээг нэмэгдүүлэх зорилготой. Уурхайн нөлөөллийн талбай ~200 га.


- **Орон нутгийн экосистемийг хамгаалахыг зорин ажилладаг**

Эрдэнэ Ресурс нь төслийн талбайд 2 га-д орон нутгийн онцлог ургамал, модыг тарьж, өнөөг хүртэл 10,000 гаруй суулгац бэлтгэсэн. Компани нь “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэн, 2030 он хүртэл нэг сая мод тарих амлалт хүлээсэн. Бид орон нутгийн ан амьтан, ургамлын амьдрах орчныг хянаж, хяналт шинжилгээ хийж ажилладаг.

- **Эрдэнэ Ресурс нь олон улсын шилдэг туршлага, стандартуудыг эрхэмлэн ажилладаг**

Эрдэнэ Ресурс нь Олон улсын санхүүгийн корпорацийн санаачилсан Усны менежментийн сайн дурын кодекст нэгдсэн. Энэхүү санаачилгыг Канад Улсын засгийн газар, 2030 Усны нөөцийн групп, ЕСБХБ болон Уул уурхай, металлын олон улсын зөвлөл дэмжин ажилладаг. Бид орон нутаг болон олон улсын байгаль орчны кодекс, заавар, стандарт шаардлагуудыг мөрдлөг болгон ажилладаг.





ERDENE

RESOURCE DEVELOPMENT

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

Утас (Канад): +1 – 902 – 423 – 6419


Утас (Монгол): +976 – 7777 – 8534

Вебсайт: www.erdene.com

Имэйл: info@erdene.com

СОШИАЛ ХАЯГУУД

 ErdeneRes

 Erdene Resource Development Corp.

ХАВСРАЛТ



УДИРДЛАГЫН БАГ

Монгол Улсын хайгуул, олборлолтын салбар дахь туршлагатай баг

Геологи



Петер Акерли
Ерөнхийлөгч & Гүйцэтгэх захирал

Ашигт малтмалын хайгуул, санхүүжилт, төсөл хөгжүүлэлт болон хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудыг удирдах чиглэлээр 30 жил ажилласан туршлагатай.



Майкл Х.Гиллис
Үйл ажиллагаа хариуцсан дэд ерөнхийлөгч

Эрдсийн хайгуулын салбарт 30 гаруй жил ажилласан туршлагатай геологич бөгөөд томоохон төслүүд дээр удирдах албан тушаал хашиж байсан.



Г.Бат-Эрдэнэ
Ахлах геологич

Монгол Улсын эрдсийн хайгуулын салбарт 25 гаруй жил ажилласан туршлагатай геологич.

Олборлолт



Паул Корпи
Техникийн ахлах зөвлөх

Металлургийн инженер & Уурхайн зөвлөх чиглэлээр 40 гаруй жил ажилласан туршлагатай ба Бороо Гоулд уурхайн Ерөнхийлөгч ба Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан.



Жон М.Л.Лёнс
Эрдэнэ Монгол ХХК-ийн Өсөлт хөгжил хариуцсан захирал

Монгол Улсад тогтвортой хөгжил, орон нутгийн харилцаа, компанийн хариуцлагын чиглэлээр 15 гаруй жил ажилласан туршлагатай удирдах



Канад улсад төвлөрсөн



Монгол улсад төвлөрсөн

Санхүү / Захиргаа



Роберт Женкинс
Санхүү хариуцсан захирал

Компанийн санхүүжилт, үйл ажиллагаа, төслийн удирдлагын чиглэлээр 20 гаруй жил ажилласан туршлагатай Итгэмжлэгдсэн нягтлан бодогч.



Б.Баярмаа
Захиргааны ерөнхий захирал

Монгол Улсын ашигт малтмал, уул уурхайн салбарт 15 гаруй жил захиргааны чиглэлээр удирдах албан тушаалд ажилласан туршлагатай.



А.Билгүүн
Дэд ерөнхийлөгч,
Эрдэнэ Монгол ХХК-ийн Гүйцэтгэх захирал

ТХБ, АХБ-д бүртгэлтэй Компаниудад санхүүжилтийн чиглэлээр зөвлөн, 15 гаруй жил ажилласан туршлага бүхий уул уурхайн санхүүгийн мэргэжилтэн. Итгэмжлэгдсэн санхүүгийн шинжээч.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Монголын уул уурхайн салбарын туршлага

МОНГОЛ УЛС



Др. Анна Биолик ^{1,3}
ТУЗ-ийн гишүүн

Монгол, Казахстан, Кыргызстан, Тажикстан улсуудад Элчин сайдаар ажиллаж байсан Төв Азийн бизнес, дипломат харилцааны чиглэлээр мэргэшсэн Канадын тэргүүлэгч мэргэжилтнүүдийн нэг.



Камерон МакРэй ⁴
ТУЗ-ийн гишүүн

Камерон Рио Тинтод 28 жил ажиллах хугацаандаа Монгол Улсад Оюу Толгой ХХК-ийн захирлаар томилогдон, 6 тэрбум ам.долларын зэс- алтны уурхайн бүтээн байгуулалтыг эхлүүлэн ажиллаж байсан туршлагатай.



Петер Акерли ⁴
Ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал,
ТУЗ-ийн гишүүн

Ашигт малтмалын хайгуул, санхүүжилт, төсөл хөгжүүлэлт болон хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудыг удирдах чиглэлээр 30 жил ажилласан туршлагатай.



Лэйтон Крофт ^{1,3,5}
ТУЗ-ийн дарга

Айванхоу Майнс, Рио Тинто, Пийбоди Энержи ба Панконтинентал Ресурсиз зэрэг уул уурхайн компаниудад 16 жил, Монгол улсад удирдлагын төвшинд 27 жилийн турш ажилласан туршлагатай.



Кеннет МакДоналд ^{1,2,5}
ТУЗ-ийн гишүүн

Уул уурхайн санхүүгийн чиглэлээр 40 жил ажилласан итгэмжлэгдсэн нягтлан бодогч тэрээр Эрдэнэ Ресурсд 17 жилийн турш Санхүү хариуцсан захирал болон дэд ерөнхийлөгчөөр ажилласан.

НИЙТ ТУРШЛАГА

> 50 жил Монгол улсад

> 50 жил санхүүгийн зах зээлд

> 100 жил хайгуул/ олборлолтын чиглэлээр ажилласан туршлагатай

88% хараат бус



Дэвид Мошер ²
ТУЗ-ийн гишүүн

Уул уурхай, геологийн чиглэлээр 35 жил ажилласан туршлагатай. Хай Ривер Голд компанийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан ба Буркина Фасо, ОХУ-д орд хөгжүүлсэн туршлагатай.



Хэдли Виддап ^{2,4,5}
ТУЗ-ийн гишүүн

Уул уурхайн төслүүдийн үнэлгээ, хөгжүүлэлтийн үе шатуудад 20 гаруй жил ажилласан туршлагатай геологич, хөрөнгө оруулалтын менежер юм.

МОНГОЛ УЛС

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛТ

ТЕХНИК

1. Аудит ба эрсдэлийн удирдлагын хороо
2. Цалин урамшууллын хороо
3. Компанийн засаглал ба мэдээлэл түгээх хороо
4. Техникийн хороо
5. Тусгай хороо

МОНГОЛ УЛС – УУЛ УУРХАЙД ТУЛГУУРЛАСАН ЭДИЙН ЗАСАГ

Засгийн газар уул уурхайг хөгжүүлэх замаар эдийн засгийг эрчимжүүлэхэд анхаарч байна

Хөгжиж буй уул уурхайн салбар

- +60,000 уул уурхайн мэргэжилтнүүд
- Оюу Толгойн ~19,000 ажилтнуудын ~ 97% нь Монголчууд
- Газар нутгийн 70%-д хайгуул хязгаарлагдмал хийгдсэн
- Засгийн газраас уул уурхайтай холбоотой дэд бүтцэд хөрөнгө оруулна


Зохицуулалт, хууль журмын дэмжлэг

- Алтны нөөц ашигласны төлбөр 5%, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 25%
- Тогтворжуулах гэрчилгээ нь 7 жилийн турш татварын хэмжээг тогтворжуулна
- Канад болон 20 гаруй улстай давхар татварын гэрээтэй
- Канад - Монголын гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, хамгаалах гэрээ (FIPA)

ОХУ, БНХАУ-ын хооронд орших хөгжиж буй ардчилсан улс

- Хүн амын нягтрал бага: Газар нутгийн хэмжээгээр дэлхийн 18 дахь том Монгол улс нь 3.5 сая хүн амтай
- Дэлхийн банкны ДНБ-ийн өсөлтийн прогноз: 2024 онд 6.2%, 2025 онд 6.4%
- Ардчилсан сонгуулийн 30 жилийн түүхтэй
- Нийт хүн амын 98% нь бичиг үсэг тайлагдсан ба боловсролтой, харьцангуй залуу хүн амтай

Уул уурхайн эдийн засагт оруулж буй хувь нэмэр



МОНГОЛЫН ЭРДСИЙН ОЛБОРЛОЛТ

Алт, зэсийн үндсэн ордын олборлолт нэмэгдэж байна

БАЯН АЙРАГ

Баян Айраг ХХК



1 сая унц ил уурхай,
нуруулдан уусгах технологи

ЗААМАР

Шороон ордууд



Туул голын хэсгээс 50 кмт
орших алтны шороон орд

БОРОО

Бороо Гоулд ХХК



1.5 сая унц алт олборлосон, дунджаар
\$500 /унц бэлэн мөнгөний зардал бүхий

ГАЦУУРТ


Бороо Гоулд ХХК




1.6 сая унц нөөц бүхий ил уурхай,
тусгай зөвшөөрлийн шатанд явж буй

АЛТАН ЦАГААН ОВОО

Степпе Гоулд



0.7 сая унц алт (+5 сая унц мөнгө),
@ 1.3 г/т алтны агуулга бүхий



ЦАГААН ЦАХИР

Наран Мандал



2016 оны эхээр
олборлолт эхэлсэн

БАЯН ХӨНДИЙ & АЛТАН НАР

Эрдэнэ Ресурс Девелопмент



Шинэ алтны дүүрэг, өндөр
агуулга бүхий хөгжүүлэлтийн
шатанд явж буй

БАЯНХОНГОР

Бичил уурхай



Алтны шороон орд

ОЮУ ТОЛГОЙ

Рио Тинто



53 сая унц алтны нөөц бүхий
ил/далд уурхай

ОЮУТ УЛААН

Занаду



Шинээр алтны дүүрэг, өндөр
агуулга бүхий, анхан шатанд
явж буй хөгжүүлэлт

ОЮУ ТОЛГОЙ – ДЭЛХИЙН ХЭМЖЭЭНИЙ ЗЭС-АЛТНЫ ДҮҮРЭГ

Монгол Улсын зүүн өмнөд хэсэгт орших дэлхийн хамгийн том зэс-алтны уурхайнуудын нэг

- 2023 онд дэлхийн дөрөв дэх том зэсийн уурхай болох төсөөлөлтэй
- 30 жилийн турш жилд 290 мян.тн зэс болон 260 мян.унц алт олборлох боломжтой (олборлолтын оргил үед жилд 500 мян.т зэс олборлох боломжтой)
- Өндөр агуулга / бага зардал / ашиглалтын хугацаа урт
- Дэлхийн хамгийн орчин үеийн, аюулгүй тогтвортой уурхайнуудын нэг; нийт ажилтнуудын 23% нь эмэгтэй
- 39 сая.тн зэс, 53 сая.унц алтны нөөц¹
 - Уурхай ашиглалтад орсноос хойш 3.3 тэр.фунт зэс болон 3 сая.унц алтны олборлолтыг хийсэн
- Далд уурхайн олборлолт 2022 оны 02 сараас эхэлсэн

Тэмдэглэл:

1. Contained copper = 8.36Mt in M&I & 30.3Mt in Inferred
Contained gold = 9.11Moz in M&I & 43.8Moz in Inferred
Эх сурвалж: Rio Tinto 2022 Annual Report and Investor Presentation




Above: Oyu Tolgoi's underground mine. Source: <http://ot.mn/>



ОЮУ ТОЛГОЙ – ДЭЛХИЙН ХЭМЖЭЭНИЙ ЗЭС-АЛТНЫ ДҮҮРЭГ

Монгол Улсын зүүн өмнөд хэсэгт орших дэлхийн хамгийн том зэс-алтны уурхайнуудын нэг



БАЯНХӨНДИЙ АЛТНЫ ТӨСЛИЙН ГЕОЛОГИЙН БОЛОН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН НӨӨЦ

Бага сульфиджилт бүхий эпитеpmаль орд

| Геологийн нөөц | Тонн | Au агуулга | Агуулсан Au | Ag агуулга | Агуулсан Ag |
|------------------|----------|------------|-------------|------------|-------------|
| Ангилал | (сая.тн) | (г/т) | (мян.унц) | (г/т) | (мян.унц) |
| Баттай | 4.0 | 3.03 | 394 | 1.44 | 187 |
| Бодитой | 3.3 | 2.04 | 219 | 1.22 | 131 |
| Баттай & Бодитой | 7.4 | 2.58 | 613 | 1.34 | 319 |
| Боломжтой | 0.2 | 1.08 | 6 | 1.32 | 8 |

Тэмдэглэл:

- 2023.04 сарын байдлаарх нөөцийн мэдээлэл.
- Геологийн нөөц нь эдийн засгийн хувьд үр ашигтай эсэхийг тооцоогүй.
- Бүхэлдсэн дүн нь нийлбэр дүнд нөлөөлж болзошгүй.
- Геологийн нөөцийн батлагдсан огноо: 2023 оны 4 сарын 20
- Ил уурхайн геологийн нөөц нь уурхайн ханын хязгаарын оновчлолд багтсан.
- Дараах үзүүлэлтэд тулгуурлан ил уурхайн захын алтны агуулгыг 0.4 г/т тооцсон:
 - Алтны үнийг нэг унц нь US\$2,000-аар тооцоолов.
 - Алт авалт 95%
 - Олборлолтын зардал нэг тонн тутамд \$3.00
 - Олборлолтын зардал болон ерөнхий, захиргааны зардал нэг тонн тутамд \$22.00
 - Нэгдмэл утгад 1м-т алтны агуулгыг 200 г/т, мөнгөний агуулгыг 50 г/т-оор хязгаарласан.
 - Нягтаршил нь литологиос хамааран 2.58 г/см³ - 2.66 г/см³ хооронд хэлбэлзэнэ.

| Үйлдвэрлэлийн нөөц | Тонн | Au агуулга | Агуулсан Au | Ag агуулга | Агуулсан Ag |
|--------------------|----------|------------|-------------|------------|-------------|
| Ангилал | (сая.тн) | (г/т) | (мян.унц) | (г/т) | (мян.унц) |
| Батлагдсан | 2.7 | 4.1 | 360.2 | 1.7 | 159.4 |
| Магадласан | 1.1 | 3.0 | 104.7 | 1.7 | 61.1 |
| Нийт | 3.8 | 3.8 | 464.9 | 1.7 | 220.5 |

Тэмдэглэл:

- Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо 2023 оны 8 сард хүчин төгөлдөр болсон
- Геологийн нөөцийн тооцооллыг Австралийн газар зүйн шинжлэх ухааны хүрээлэнгийн гишүүн, RPM Global компанийн ажилтан Бат-Очирын Оюунбат ("Oyunchat Bat-Ochir") боловсруулж баталгаажуулсан. Оюунбат нь ордын эрдэсжилт болон ордын хэв маяг, хэлбэрийн талаар хангалттай туршлагатайгаас гадна CIM-ийн ил тод байдлын стандартад тодорхойлсон Мэргэшсэн этгээдийн шаардлага хангасан мэргэжилтэн юм.
- Дээрх хүснэгтэд тайлагнасан бүх нөөцийн тооцоолууд нь 2022 оны 11-р сарын 1-ны өдрийн тооцоолол юм. Нөөцийн тайлан нь нарийн өгөгдөл биш бөгөөд судалгааны үр дүн, байршил, хэлбэр болон тархац зэрэг хязгаарлагдмал мэдээлэлд тулгуурлан боловсруулагдсан. Дээрх өгөгдлүүд нь тооцооллын харьцангуй байдалд тулгуурласан бүхэл тоогоор тоймлосон болно. Үүнээс шалтгаалсан тооцооллын зөрүү гарах магадлалтай.
- Нөөцийн тайланг хуурай, газар дээрх төлөвт нь үндэслэн тайлагнасан.
- Геологийн нөөцийн захын агуулгыг исэлдсэн болон шилжилтийн хүдрийн хувьд 0.35 г/т, анхдагч хүдрийн хүрээнд 1.02 г/т байхаар тооцоолсон. Эдгээр захын агуулгын тооцоог RPM-ийн дотоод захын агуулгын тооцоолуураар тодорхойлсон бөгөөд үүнд хүдрийн 5%-ийн алдагдал 10%-ийн бохирдол ба алтны үнийг нэг унц нь US\$1,723 байхаар тооцоолсон. Мөн олборлолтын зардал нэг тонн тутамд US\$3, нэг тонн хүдрийг боловсруулах зардал US\$16, тээрэм болон боловсруулалтын хувь хэмжээ нь исэлдсэн хүдрийн хувьд 90%, шилжилтийн хүдрийн хувьд 87%, анхдагч хүдрийн хувьд 30% байх төсөөлөлд тулгуурлан боловсруулсан. Нөөцийн тайланд уурхайн оновчилсон хязгаарыг алтны үнэ \$2,000 ам.доллараар төсөөлсөн нь урт хугацааны урьдчилан таамагласан үнээс 1.4 дахин өндөр байна.
- Дээрх геологийн нөөц нь эдийн засгийн тооцоололд ороогүй бөгөөд эдийн засгийн хувьд үр ашигтай эсэхийг тооцоогүй болно.



ХАР МОРЬ АЛТНЫ ОРДЫН ГЕОЛОГИЙН БОЛОН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН НӨӨЦ

Эпитермаль исэлдсэн орд

| | Бодитой геологийн нөөц | | | Боломжтой геологийн нөөц | | |
|-------------|------------------------|------------|-------------|--------------------------|------------|-------------|
| | Тонн | Au агуулга | Агуулсан Au | Тонн | Au агуулга | Агуулсан Au |
| Ангилал | (мян.т) | (г/т) | (мян.унц) | (мян.т) | (г/т) | (мян.унц) |
| Исэлдсэн | 578 | 3.0 | 56.2 | 75 | 1.1 | 2.7 |
| Шилжилтийн | 99 | 1.5 | 4.8 | 109 | 1.2 | 4.1 |
| Анхдагч | 5 | 4.9 | 0.7 | -- | -- | -- |
| Нийт | 682 | 2.8 | 61.7 | 184 | 1.2 | 6.8 |

Тэмдэглэл:

- Геологийн нөөцийн тооцооллыг Австралийн газар зүйн шинжлэх ухааны хүрээлэнгийн гишүүн, RPM Global компанийн ажилтан Бат-Очирын Оюунбат ("Oyunbat Bat-Ochir") боловсруулж баталгаажуулсан. Оюунбат нь ордын эрдэсжилт болон ордын хэв маяг, хэлбэрийн талаар хангалттай туршлагатайгаас гадна CIM-ийн ил тод байдлын стандартад тодорхойлсон Мэргэшсэн этгээдийн шаардлага хангасан мэргэжилтэн юм.
- Дээрх хүснэгтэд тайлагнасан бүх нөөцийн тооцооллууд нь 2022 оны 11-р сарын 1-ны өдрийн тооцоолол юм. Нөөцийн тайлан нь нарийн өгөгдөл биш бөгөөд судалгааны үр дүн, байршил, хэлбэр болон тархац зэрэг хязгаарлагдмал мэдээлэлд тулгуурлан боловсруулагдсан. Дээрх өгөгдлүүд нь тооцооллын харьцангуй байдалд тулгуурласан бүхэл тоогоор тоймд болно. Үүнээс шалтгаалсан тооцооллын зөрүү гарах магадлалтай.
- Нөөцийн тайланг хуурай, газар дээрх төлөвт нь үндэслэн тайлагнасан.
- Геологийн нөөцийн захын агуулгыг исэлдсэн болон шилжилтийн хүдрийн хувьд 0.35 г/т, анхдагч хүдрийн хүрээнд 1.02 г/т байхаар тооцоолсон. Эдгээр захын агуулгын тооцоог RPM-ийн дотоод захын агуулгын тооцоолуураар тодорхойлсон бөгөөд үүнд хүдрийн 5%-ийн алдагдал 10%-ийн бохирдол ба алтны үнийг нэг унц нь US\$1,723 байхаар тооцоолсон. Мөн олборлолтын зардал нэг тонн тутамд US\$3, нэг тонн хүдрийг боловсруулах зардал US\$16, тээрэм болон боловсруулалтын хувь хэмжээ нь исэлдсэн хүдрийн хувьд 90%, шилжилтийн хүдрийн хувьд 87%, анхдагч хүдрийн хувьд 30% байх төсөөлөлд тулгуурлан боловсруулсан. Нөөцийн тайланд уурхайн оновчилсон хязгаарыг алтны үнэ \$2,000 ам.доллараар төсөөлсөн нь урт хугацааны урьдчилан таамагласан үнээс 1.4 дахин өндөр байна.
- Дээрх геологийн нөөц нь эдийн засгийн тооцоололд ороогүй бөгөөд эдийн засгийн хувьд үр ашигтай эсэхийг тооцоогүй болно.

| Үйлдвэрлэлийн нөөц | Тонн | Au агуулга | Агуулсан Ag |
|--------------------|------------|------------|-------------|
| Ангилал | (сая.т) | (г/т) | (мян.унц) |
| Батлагдсан | -- | -- | -- |
| Магадласан | 0.2 | 7.0 | 48.8 |
| Нийт | 0.2 | 7.0 | 48.8 |

Тэмдэглэл:

- Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо 2023 оны 8 сарын 1-ээс хүчин төгөлдөр болсон бөгөөд O2 Mining Limited компанийн Жулиен Лауренс нь мэргэшсэн этгээд;
- Ашигт малтмалын нөөцийн тооцооллыг 2014 оны Канадын Уул уурхай, Металлурги болон Газрын тосны хүрээлэнгийн (CIM) Тодорхойлолтын Стандарт (2014 CIM Тодорхойлолтын Стандарт) болон 2003 оны CIM Шилдэг Практик Удирдамжийн дагуу бэлтгэсэн;
- Нөөцийг ил уурхайн аргаар олборлохоор тооцоолсон;
- Хаягдал болон хүдрийн захын хязгаарыг моделийн блок бүрийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөрт тулгуурлан тооцсон. БЦАТ-ийг уурхайн бус алдагдал, тээвэрлэлт, хайлуулах болон цэвэршүүлэх зардлуудад тулгуурлан тооцоолсон;
- Нөөцийг тооцоолохдоо нэг унц алтны үнэ \$1,816 ам.доллар төсөөлөл дээр үндэслэсэн;
- Үйлдвэрлэлийн нөөцийг хорогдуулсан олборлолтын блок моделд суурилж боловсруулсан бөгөөд 10%-ын дундаж хорогдол болон 2.5%-ын алдагдалтай байхаар тооцсон.



АЛТАН НАР ОРДЫН НӨӨЦ

Дундаж сульфиджилт бүхий эпитеpmаль алт-мөнгө-хар тугалга-цайрын орд

| Бодитой | Тонн | Au | Ag | Zn | Pb | AuEq | Au | Ag | Zn | Pb | AuEq |
|----------|---------|-------|-------|-----|-----|-------|-----------|-----------|---------|---------|-----------|
| Ангилал | (сая.т) | (г/т) | (г/т) | (%) | (%) | (г/т) | (мян.унц) | (мян.унц) | (мян.т) | (мян.т) | (мян.унц) |
| Исэлдсэн | 0.6 | 2.0 | 12.7 | 0.6 | 1.0 | 3.1 | 39.3 | 244.3 | 3.8 | 6.3 | 59.6 |
| Анхдагч | 4.4 | 2.0 | 15.0 | 0.6 | 0.5 | 2.8 | 278.4 | 2,105.4 | 27.8 | 22.7 | 393.4 |
| Нийт | 5.0 | 2.0 | 14.8 | 0.6 | 0.6 | 2.8 | 317.7 | 2,349.7 | 31.6 | 29.0 | 453.0 |

| Боломжтой | Тонн | Au | Ag | Zn | Pb | AuEq | Au | Ag | Zn | Pb | AuEq |
|-----------|---------|-------|-------|-----|-----|-------|-----------|-----------|---------|---------|-----------|
| Ангилал | (сая.т) | (г/т) | (г/т) | (%) | (%) | (г/т) | (мян.унц) | (мян.унц) | (мян.т) | (мян.т) | (мян.унц) |
| Исэлдсэн | 0.8 | 1.8 | 7.5 | 0.6 | 0.9 | 2.6 | 43.3 | 183.7 | 4.3 | 6.5 | 64.2 |
| Анхдагч | 2.7 | 1.7 | 8.0 | 0.7 | 0.6 | 2.5 | 142.4 | 682.1 | 19.4 | 15.8 | 212.8 |
| Нийт | 3.4 | 1.7 | 7.9 | 0.7 | 0.7 | 2.5 | 185.7 | 865.8 | 23.7 | 22.3 | 277.1 |

Тэмдэглэл:

1. Энэхүү нөөцийн тайлан дахь мэдээллүүд нь RPM-ийн ажилтан, Австралийн Геосудлаачдын Институтын гишүүн Жереми Кларк (Jeremy Clark)-ийн хяналт дор боловсруулагдсан. Ноён Кларк нь дурдсан ордын хүдэржилтийн талаар өндөр туршлагатай бөгөөд CIM Тодруулгын стандартын дагуу Мэргэшсэн этгээдийн шаардлага хангасан мэргэжилтэн юм.
2. Нөөцийн тайлангийн талаар дээрх хүснэгтэд багтсан мэдээлэл нь 2018 оны 5-р сарын 7 хүртэл хийгдсэн өрмийн судалгааны үр дүнд тулгуурласан. Нөөцийн тайлан нь нарийн өгөгдөл биш бөгөөд судалгааны үр дүн, байршил, хэлбэр болон тархац зэрэг хязгаарлагдмал мэдээлэлд тулгуурлан боловсруулагдсан. Дээр өгөгдсөн өгөгдлүүд нь тооцооллын харьцангуй байдалд тулгуурлан бүхэл тоонд шилжүүлсэн болно. Үүнээс шалтгаалсан тооцооллын зөрүү гарах магадлалтай.
3. Алттай дүйцэх нэгж (AuEq) нь урт хугацааны 2023 - 2027 "Energy & Metals Concensus Forecasts" –ыг ашиглан алтны үнийг US\$1310/унц, мөнгөний үнийг US\$17.91/унц, хар тугалгын үнийг US\$1.07/фунт, цайрын үнийг US\$1.42/фунт байхаар тооцоолсон. Металл авалтад тохируулга хийж, алт, мөнгөний хувьд пиритийн баяжмалыг ялгахад флотаци ашигласан компанийн урьдчилсан үр дүнд үндэслэсэн. Дээрх металлуудын агуулга, агуулагдах металлын агууламжийг харгалзан бүх түүхий эдийг эдийн засгийн хувьд олборлох боломжтой гэж үзсэн. Алттай дүйцэх нэгжийн агуулгад ашигласан томъёо: AuEq г/т = Au г/т + Ag г/т*0.0124+Pb%*0.509+Zn%*0.578 ба металл авалт 88.8% Au, 80.6% Ag, 80.4% Pb ба 69.1% Zn. b. Алттай дүйцэх нэгжийн унцыг тооцоолохдоо ашигт малтмалын нөөцийн тонныг алттай дүйцэх агуулгаар үржүүлж, унц болгон хөрвүүлэх замаар тооцдог. Алттай дүйцэх нэгжийн унцыг тооцоолохдоо ашигласан томъёо: AuEq Oz = [тонн x AuEq агуулга (г/т)]/31.1035.
4. Нөөцийн тайланг хуурай, газар дээрх төлөвт нь үндэслэн тайлагнасан.
5. Геологийн нөөцийн захын агуулгыг ил уурхайн бүрхүүлээс дээш хүдрийн хувьд 0.7 г/т, ил уурхайн бүрхүүлээс доош хүдрийн хүрээнд 1.4 г/т байхаар тооцоолсон. Эдгээр захын агуулгын тооцоог RPM-ийн дотоод захын агуулгын тооцоолуураар тодорхойлсон бөгөөд алтны үнийг нэг унц нь US\$1,310, захын агуулгыг ил уурхайн бүрхүүлээс дээш 0.7 г/т алттай дүйцэх нэгж, ил уурхайн бүрхүүлээс доош 1.4 г/т алттай дүйцэх нэгж байхаар тооцоолсон. Мөн олборлолтын зардал нэг тонн тутамд US\$6, нэг тонн хүдрийг боловсруулах зардал US\$20, тээрэм болон боловсруулалтын хувь хэмжээ нь алтны хувьд 88%, мөнгө 80.6%, хар тугалга 80.4% болон цайр 69.1% байх төсөөлөлд тулгуурлан боловсруулсан.
6. Дээрх геологийн нөөц нь эдийн засгийн тооцоололд ороогүй бөгөөд эдийн засгийн хувьд үр ашигтай эсэхийг тооцоогүй болно.



ЗУУН МОД ОРДЫН НӨӨЦ

16 км диаметр бүхий порфирийн цогцолбор

| Зуун Мод | Тонн | Мо агуулга | Агуулсан Мо | Си агуулга | Агуулсан Си |
|------------------|---------|------------|-------------|------------|-------------|
| Ангилал | (сая.т) | (%) | (сая.фунт) | (%) | (сая.фунт) |
| Баттай | 40 | 0.056 | 49.5 | 0.064 | 57.0 |
| Бодитой | 178 | 0.057 | 224.0 | 0.070 | 273.7 |
| Баттай & Бодитой | 218 | 0.057 | 273.5 | 0.069 | 330.7 |
| Боломжтой | 138 | 0.052 | 157.7 | 0.065 | 197.7 |

Тэмдэглэл:

1. 2011 оны 5 сард батлагдсан.
2. Захын агуулга: 0.04% Мо
3. 1 тонн = 2204.64 фунт
4. Бүхэлдсэн дүн нь нийлбэр дүнд нөлөөлж болзошгүй.


БАЯНХӨНДИЙ АЛТНЫ ТӨСЛИЙН ШИНЭЧИЛСЭН ТЭЗҮ

Үйл ажиллагааны зардал харьцангуй бага

Үйл ажиллагааны зардлууд



Хөрөнгийн зардлууд



| Үйл ажиллагааны зардал | УАХ сая ам.дол | ам.дол/унц | ам.дол/т |
|---|----------------|--------------|--------------|
| Олборлолтын зардал | \$165 | \$347 | \$41 |
| Боловсруулалтын зардал | \$166 | \$349 | \$41 |
| Ерөнхий ба захиргааны зардал | \$20 | \$43 | \$5 |
| Нийт үйл ажиллагааны зардал | \$352 | \$739 | \$88 |
| Нөөц ашигласны төлбөр ба бусад | \$51 | \$108 | \$13 |
| Ашиглалтын үеийн хөрөнгө оруулалт ба уурхайн хаалтын зардал | \$10 | \$22 | \$3 |
| Алт үйлдвэрлэх нэгжийн өртөг (AISC) | \$414 | \$869 | \$103 |

| Хөрөнгийн зардал | сая ам.дол |
|--|--------------|
| Боловсруулах үйлдвэр | \$47 |
| Боловсруулах үйлдвэрийн бус дэд бүтэц | \$14 |
| Барилга байгууламжийн шууд бус зардал | \$27 |
| Бүтээн байгуулалтын зардал | \$88 |
| Олборлолтын өмнөх зардал | \$2 |
| Болзошгүй зардал (12%) | \$10 |
| Нийт бүтээн байгуулалтын зардал | \$100 |